

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2024/189/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Дорноговь аймаг Сайншанд сум 2024 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2024-02-23 № 1-6/230

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Н.БАТМӨНХ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 2 тушаалыг хуулийн хугацааг хоцроож, 3 тушаал огт

010020057

мэдээлээгүй байна. Эдгээр нь нийтдээ 341.6 мянган төгрөгийн үнэ бөгөөд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн хуулийн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 24 ширхэг 29.8 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 7 ширхэг 6.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. Энэ зөрчил нь НББ-ийн тухай хуулийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасан заалтуудыг тус зөрчсөн байна.

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчил нь үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 81.9 хувийн биелэлттэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	116,974,432.95	194,234,189.02
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	59,680,412.05	139,927,909.05
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	59,680,412.05	139,927,909.05
3121	Төгрөг	4,883,746.00	4,042,146.00
31211	Төрийн сангийн харилцах	4,883,746.00	4,042,146.00
3122	Гадаад валют	54,796,666.05	135,885,763.05
31221	Төрийн сангийн харилцах	54,796,666.05	135,885,763.05
35	БАРАА МАТЕРИАЛ	57,294,020.90	54,306,279.97
351	Түүхий эд материал	1,420,900.00	1,420,900.00
35110	Тусгай зориулалттай материал	1,163,200.00	1,163,200.00
35130	Эм боох материал	257,700.00	257,700.00
354	Хангамжийн материал	55,873,120.90	52,885,379.97
35410	Бичиг хэргийн материал	661,000.00	706,200.00
35420	Аж ахуйн материал	36,120,648.98	35,704,348.98
35460	Хүнсний материал	1,802,877.00	1,607,673.40
35470	Бусад хангамжийн материал	441717,288,594.92	14,867,157.59
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,418,890,220.76	1,382,755,918.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,415,890,220.76	1,382,755,918.40
392	Биет хөрөнгө	1,408,062,887.32	1,375,016,584.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,417,374,331.34	1,417,374,331.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(94,692,402.13)	(118,447,043.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	72,204,848.00	74,030,333.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,355,038.09)	(45,012,558.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,454,194.05	51,268,394.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,371,808.85)	(20,423,134.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,423,818.00	17,843,918.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,126,885.65)	(3,467,518.14)
39217	Ном	2,151,830.65	1,849,863.65
393	Биет бус хөрөнгө	7,827,333.44	7,739,333.48
39301	Програм хангамж	352,000.00	352,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(234,666.56)	(322,666.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,710,000.00	7,710,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,532,864,653.71	1,576,990,107.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,513,632.00	504,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,513,632.00	504,000.00
413	Өглөг	1,513,632.00	504,000.00
4136	Бусад өглөг	-	504,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	504,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,531,351,021.71	1,576,486,107.42
51	Засгийн газрын хувь оролцоо	1,531,351,021.71	1,576,486,107.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	758,302,070.82	758,302,070.82
512	Хуримтлагдсан үр дүн	761,381,827.58	806,516,913.29
51210	Өмнөх үеийн үр дүн	761,381,827.58	761,381,827.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	45,135,085.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,667,123.31	11,667,123.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,532,864,653.71	1,576,990,107.42

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	562,604,645.00	733,654,216.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,500.00	6,440,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	103,500.00	6,440,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,500.00	2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	2,000,000.00
120017	Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө		4,440,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,501,145.00	727,214,216.14
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	449,550,900.00	642,311,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	449,550,900.00	642,311,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	112,950,245.00	84,902,916.14
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	112,950,245.00	84,902,916.14
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	547,351,459.09	688,217,163.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	547,351,459.09	688,217,163.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	546,198,259.09	684,304,905.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,133,897.95	441,028,359.00
210101	Үндсэн цалин	274,633,148.95	349,911,868.00
210102	Нэмэгдэл	54,071,088.00	81,428,703.00
210104	Урамшуулал	5,954,661.00	9,687,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,355,692.00	56,038,992.00
210201	Тэтгэврийн даатгал	28,887,480.00	37,945,822.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,488,499.00	4,523,316.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,703,082.00	3,618,595.00
210204	Ажилгүйдлийн даатгал	725,417.00	904,424.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,551,214.00	9,046,835.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,198,665.00	84,602,916.14
210301	Гэрэл, цахилгаан	5,185,045.00	7,316,115.76
210302	Түлш, халаалт	68,226,872.00	70,157,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,786,748.00	7,129,400.38
2104	Хангамж, бараа материалын зардал	7,393,944.82	8,340,077.33
210401	Бичиг хэрэг	2,447,200.00	1,442,700.00
210402	Тээвэр, шатахуун	860,200.00	1,269,440.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,848,610.00	3,206,500.00
210408	Бараа материал акталсны зардал	1,693,734.82	2,421,437.33
2105	Нормативт зардал	36,733,695.00	43,182,725.60
210502	Хоол, хүнс	36,733,695.00	43,182,725.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500.00	87,500.00
210604	Урсгал засвар	4,500.00	87,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	675,000.00	694,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	675,000.00	694,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,702,864.32	50,330,335.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,879,300.00	4,422,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	39,268,764.32	45,907,435.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,153,200.00	3,912,258.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,153,200.00	3,912,258.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,153,200.00	3,912,258.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,253,185.91	45,437,052.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	76,215.22	301,967.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	76,215.22	301,967.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(76,215.22)	(301,967.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	15,176,970.69	45,135,085.71

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		4417144353 EUA0056 9025707
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	562,604,645.00	729,214,216.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,500.00	2,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	103,500.00	2,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,500.00	2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,501,145.00	727,214,216.14
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	449,550,900.00	642,311,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	449,550,900.00	642,311,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	112,950,245.00	84,902,916.14
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	112,950,245.00	84,902,916.14
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	508,961,178.95	640,331,619.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	508,961,178.95	640,331,619.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,807,978.95	636,419,361.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,131,557.95	441,028,359.00
210101	Үндсэн цалин	274,630,808.95	349,911,868.00
210102	Нэмэгдэл	54,071,088.00	81,428,703.00
210104	Урамшуулал	5,954,661.00	9,687,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,842,060.00	57,552,624.00
210201	Тэтгэврийн даатгал	27,858,210.00	39,136,236.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,367,408.00	4,604,021.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,606,210.00	3,683,198.00
210204	Ажилгүйдлийн даатгал	701,199.00	920,625.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,309,033.00	9,208,544.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,198,665.00	84,602,916.14
210301	Гэрэл, цахилгаан	5,185,045.00	7,316,115.76
210302	Түлш, халаалт	68,226,872.00	70,157,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,786,748.00	7,129,400.38
2105	Нормативт зардал	37,969,786.00	42,987,522.00
210502	Хоол, хүнс	37,969,786.00	42,987,522.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	710,200.00	300,000.00
210604	Урсгал засвар	710,200.00	300,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	675,000.00	694,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	675,000.00	694,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,280,710.00	9,253,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,911,410.00	8,017,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,369,300.00	1,236,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,153,200.00	3,912,258.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,153,200.00	3,912,258.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,153,200.00	3,912,258.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	53,643,466.05	88,882,597.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	8,635,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,635,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	8,635,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	8,635,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(8,635,100.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	53,643,466.05	80,247,497.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		59,680,412.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,680,412.05	139,927,909.05

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	758,302,070.82	17,378,040.93	689,896,264.27	1,465,576,376.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	11,747,863.62	11,747,863.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	758,302,070.82	17,378,040.93	701,644,127.89	1,477,324,239.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(5,710,917.62)	-	(5,710,917.62)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	59,737,699.69	59,737,699.69
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	758,302,070.82	11,667,123.31	761,381,827.58	1,531,351,021.71
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	758,302,070.82	11,667,123.31	761,381,827.58	1,531,351,021.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	758,302,070.82	11,667,123.31	761,381,827.58	1,531,351,021.71

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	45,135,085.71	45,135,085.71
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	758,302,070.82	11,667,123.31	806,516,913.29	1,576,486,107.42

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	691,360,900.00	563,222,203.00	128,138,697.00	81%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	691,360,900.00	563,222,203.00	128,138,697.00	81%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	688,290,200.00	560,151,545.00	128,138,655.00	81%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,332,700.00	441,028,359.00	100,304,341.00	81%
210101	Үндсэн цалин	351,803,800.00	349,911,868.00	1,891,932.00	99%
210102	Нэмэгдэл	173,401,300.00	81,428,703.00	91,972,597.00	47%
210104	Урамшуулал	16,127,600.00	9,687,788.00	6,439,812.00	60%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,801,200.00	57,552,624.00	10,248,576.00	85%
210201	Тэтгэврийн даатгал	46,105,300.00	39,136,236.00	6,969,064.00	85%
210202	Тэтгэмжийн даатгал	5,424,000.00	4,604,021.00	819,979.00	85%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,339,000.00	3,683,198.00	655,802.00	85%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,084,600.00	920,625.00	163,975.00	85%
210205	Эрүүл мэндийн даатгал	10,848,300.00	9,208,544.00	1,639,756.00	85%
2105	Нормативт зардал	55,899,500.00	42,987,522.00	12,911,978.00	77%
210502	Хоол, хүнс	55,899,500.00	42,987,522.00	12,911,978.00	77%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	944,800.00	769,000.00	175,800.00	81%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	944,800.00	769,000.00	175,800.00	81%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,312,000.00	17,814,040.00	4,497,960.00	80%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,477,500.00	14,982,340.00	4,495,160.00	77%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,834,500.00	2,831,700.00	2,800.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,070,700.00	3,070,658.00	42.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,070,700.00	3,070,658.00	42.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,070,700.00	3,070,658.00	42.00	100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	691,360,900.00	644,311,300.00	47,049,600.00	93%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	642,311,300.00	642,311,300.00	0.00	100%
310001	Улсын төсвөөс санхүүжих	642,311,300.00	642,311,300.00	0.00	100%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	49,049,600.00	2,000,000.00	47,049,600.00	4%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,000,000.00	0.00	100%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	47,049,600.00	0.00	47,049,600.00	0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	54,796,666.05	-54,796,666.05	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	135,885,763.05	-135,885,763.05	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1. Аудитаар нийт 7,005.0 мянган төгрөгийн 4 алдаа илэрснээс аудитын явцад 7,005.0 мянган төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

1. Нэг ажилтны 1.5 сая төгрөгийн цалинг Нийгмийн даатгалын тайланд 6 р сард давхардуулан тайлагнасан.
2. Жирэмсэн, амаржсаны чөлөөтэй ажилтныг нийгмийн даатгалд төрөл буруу тайлагнасан, 5,7,10 р саруудад огт тайлагнаагүй. Алдааны нийт дүн 2.2 сая төгрөг
3. Ахмадын санд нэмж хийсэн орлогын гүйлгээний бүртгэлийг 3.0 сая төгрөгөөр дутуу хийснээс үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдсэн
4. ХХОАТ-ийн тайланг бэлтгэхдээ ногдох татварыг 305.0 төгрөгөөр дутуу тооцоолсон

5.2. Аудитаар нийт 20,563.7 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 4 зөвлөмж өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1 : Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй.

Өгсөн зөвлөмж: Өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай болох.

Илрүүлэлт 2 : Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 24 ширхэг 29.8 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 7 ширхэг 6.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гүйлгээний баримт болон анхан шатны баримт болох Ebarimt баримттай тулган төлбөрийн баримт өөр дүнгээр олгогдсон бол татварын албанд болон харилцагч байгууллагад цаг тухай бүр мэдэгдэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад  
талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэг ажилтны цалинг Нийгмийн даатгалын тайланд 6 р сард давхардуулан тайлагнасан	1	1,500.00	1	1,500.00			1	1,500.00		
Жирэмсэн, амаржсаны чөлөөтэй ажилтныг нийгмийн даатгалд төрөл буруу тайлагнасан, 5,7,10 р саруудад огт тайлагнаагүй	1	2,200.00	1	2,200.00			1	2,200.00		
Ахмадын санд нэмж хийсэн орлогын гүйлгээний бүртгэлийг дутуу хийснээс үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдсэн	1	3,000.00	1	3,000.00			1	3,000.00		
ХХОАТ-ийн тайланг бэлтгэхдээ ногдох татварыг дутуу тооцоолсон	1	305.00	1	305.00			1	305.00		
<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>7,005.00</b>	<b>4</b>	<b>7,005</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>7,005</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй.	1				1			
<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>							
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 2 тушаалыг хуулийн хугацааг хоцроож, 3 тушаал огт мэдээлээгүй байна.	1	341.60			1	341.60	
<b>ДҮН</b>	1	341.60	-	-	1.00	341.60	
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>							
Евaгimт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 24 ширхэг 29.8 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 7 ширхэг 6.9 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.	1	6,891.90			1	6,891.90	
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.	1	13,330.20			1	13,330.20	
<b>ДҮН</b>	2	20,222.10			2	20,222.10	